

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2008 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Зорилт арга хэмжээ	Хэмжих нэгж шалгуур үзүүлэлт	2008 онд хүрэх түвшин хугацаа	Хариуцан хэрэгжүүлэх Засгийн газрын гишүүн холбогдох байгууллагын дарга
1	2	3	4	5
<i>Нэг. Макро эдийн засгийн бодлого</i>				
<i>Зорилт 1. Эдийн засаг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор макро эдийн засгийн тогтвортой, тэнцвэрт байдлыг хангана</i>				
1	Эдийн засгийн эрчимжилтийг бататгаж өсөлтийг нэмэгдүүлэх	ДНБ-ий бодит өсөлт /хувиар/	10.1	Ч.Улаан Засгийн газрын гишүүд
		нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ /ам.доллар/	1747.3	
2	Үнэ ханшийг зохистой түвшинд байлгах зорилгоор төрийн зохицуулалтын зарим арга хэрэгслийг ашиглаж хэрэглээний үнийн индексийг 6 хувьд байлгах бодлогыг баримтлах	хэрэглээний үнийн индекс /хувиар/	6.0	А.Батсүх Засгийн газрын гишүүд
3	Гадаад худалдааны тэнцлийг сайжруулж, гадаад валютын цэвэр албан нөөцийг өсгөх	импортыг хангах хэмжээ /долоо хоногоор/	38.5	Х.Наранхүү А.Батсүх
		цэвэр албан нөөц /сая.ам.доллар/	1662.5	
4	Өрийн зохистой удирдлагыг хангаж гадаад өрийн эдийн засагт үзүүлэх нөлөөг бууруулах	ДНБ-д гадаад өрийн үлдэгдлийн эзлэх хувь /хувиар/	55.0-аас хэтрэхгүй байх	Ч.Улаан
5	Төсвийн зарлага улмаар орлогын бодлогыг сайжруулан төсвийн зарлагын бүтэц, тайлагналт, гүйцэтгэлийн үр дүнд үндэслэсэн төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгож дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн зарлагын эзлэх хувь, хэмжээг бууруулах чиглэл баримтлах	ДНБ-д төсвийн орлогын эзлэх хэмжээ /хувиар/	44.3	Ч.Улаан
		ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хэмжээ /хувиар/	46.9	
		ДНБ-д урсгал төсвийн ашгийн эзлэх хэмжээ /хувиар/	12.0	

6	Төсвийн үр ашиггүй зардлыг багасгах зорилгоор бүтцийн өөрчлөлт хийж удирдлагын зардлыг бууруулах, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн алдагдлыг бууруулах бодлогыг баримтлах	ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хэмжээ /хувиар/	2.5-аас доош байх	Ч.Улаан Засгийн газрын гишүүд
6.1	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан илүү уян хатан болгох	-	2008.01- 2008.07	Ч.Улаан Ц.Мөнх-Оргил Н.Энхболд
6.1.1	Засгийн газраас 2007 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулж ажиллах	-	2008.01- 2008.07	Ч.Улаан Ц.Мөнх-Оргил Н.Энхболд
6.2	Монгол Улсын нэгдсэн төсвийн цар хэмжээ үлэмж нэмэгдсэнтэй уялдуулан Сангийн сайдын эрхлэх ажлын хүрээнд дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж, улс, орон нутгийн төсвийн болон Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө, нийгмийн даатгалын санд олгодог улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг чангатгаж, төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад дотоод аудит хийж зөрчил дутагдлыг цаг алдалгүй шуурхай таслан зогсоох нөхцөл, журмыг тогтоож ажиллах	-	2007.12- 2008.07	Ч.Улаан Н.Энхболд
6.3	Төрийн байгууллагуудын нэгдсэн санхүүгийн тайлан 2008 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан хугацаанд Сангийн яамны вэб хуудсанд байршуулах төсвийн гүйцэтгэлийг хянах зорилгоор Засгийн газар Сангийн яамтай холбогдох Freebalance программ хангамжийг 2008 оны I сараас эхлэн ашиглах	-	2007.12- 2008.07	Ч.Улаан
6.4	Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг Сангийн яамны вэб хуудсанд байрлуулж, төсвийн ил тод байдлыг хангах замаар хуульд заасан хүрээнд ард иргэдэд төсвийн гүйцэтгэлийн мэдээллээр нээлттэй үйлчлэх боломжийг нэмэгдүүлэх	-	2007.12- 2008.07	Ч.Улаан
6.5	Түлш, эрчим хүчний салбарт хэрэгжүүлж байгаа төслийн үр дүн, үр ашгийг тооцож шинээр хэрэгжүүлэх, төслийг үр ашиг, тэргүүлэх ач холбогдлыг харгалзан зээл, тусламжид хамруулж ажиллах	-	2007.12- 2008.07	Ч.Улаан Ч.Хүрэлбаатар
6.6	Төрийн захиргааны болон төсвийн байгууллагуудад нийтлэг үйлчилгээний нэгдсэн бодлого, зохицуулалтын арга хэрэгслийг нэвтрүүлж ажиллах, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	-	2007.12- 2008.07	Н.Энхболд Ч.Улаан

6.6.1	Яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагуудын төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын тогтоолуудын хэрэгжилтийг зохион байгуулж хяналт тавьж ажиллах	-	2007.12- 2008.07	Н.Энхболд Ч.Улаан
6.7	Хэт төвлөрсөн төрийн олон давхар хяналтын системийг задлах, зарим төрлийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн олголтыг тодорхой хугацаагаар хязгаарлан уг асуудлыг хариуцсан төрийн албан хаагчдын орон тоо, зардлыг багасгаж төрийн хүнд суртал, чирэгдлийг арилгах	-	2007.12- 2008.07	Н.Энхболд Ч.Улаан
6.7.1	Төрийн байгууллагаас олгож байгаа тусгай зөвшөөрөл хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хянан шалгаж, тусгай зөвшөөрөл олгож байгаа журмыг хялбарчлах замаар төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах арга хэмжээ авах	-	2007.12- 2008.07	Н.Энхболд Ч.Улаан
6.7.2	Зохих бэлтгэлийг хангасны үндсэн дээр аж ахуйн нэгж, байгууллагаас татварын албад санхүүгийн болон татварын тайланг цахим шуудангаар авах, улмаар зөвлөгөө, лавлагааг цахим шуудан, вэб хуудсаар өгөх ажлыг судлан өргөжүүлэх	-	2007.12- 2008.07	Н.Энхболд Ч.Улаан
6.7.3	Үндэсний татварын ерөнхий газарт //e-tax.mta.mn// хуудсыг ашиглан агентлаг байгууллагуудын санхүүгийн болон татварын холбогдох тайлангуудыг 2008 оны I улирлаас эхлэн хүргүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах	-	2007.12- 2008.07	Н.Энхболд Ч.Улаан
6.7.4	Төрийн байгууллагууд дотооддоо интернэт байгуулж, түүн дээр суурилсан дотоод үйл ажиллагаа, бичиг хэрэг хөтлөлтийг онлайн болгох замаар цаас хэрэглэх явдлыг багасгах	-	2007.12- 2008.07	Н.Энхболд Ч.Улаан
6.7.5	Бизнес эрхлэгчдэд ногдож байгаа хураамжийн ачааллыг багасгах талаар судалгаа хийж санал боловсруулах	-	2007.12- 2008.07	М.Энхболд Ч.Улаан Х.Наранхүү
7	Эдийн засаг, нийгмийн салбарт оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, төрөөс зайлшгүй шаардлагатай гэж үзсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээг өөрийн хөрөнгөөр гүйцэтгээд санхүүжилтээ нөхөн авах нөхцөлөөр хэрэгжүүлэх зарчмыг үр ашигтай хэрэгжүүлэх	ДНБ-д хөрөнгийн зардлын эзлэх хэмжээ /хувиар/	12.6	Ч.Улаан

8	Өрсөлдөөний орчныг бүрдүүлэн хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох	-	-	М.Энхболд Ц.Мөнх-Оргил
<i>Зорилт 2. Санхүүгийн салбарыг эрсдэлээс хамгаалах механизмыг бүрдүүлж даатгалын тогтолцоог боловсронгуй болгон санхүүгийн тайлагналтын олон улсын стандартыг нэвтрүүлнэ</i>				
9	Монгол Улсын зээлжих зэрэглэлийг ахиулах эдийн засаг, санхүүгийн нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллах	зэрэглэл тогтоогч компаниудын үнэлгээ	"Стандарт энд Пүүрс"-ийн үнэлгээ ВВ	Ч.Улаан А.Батсүх
10	Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системийг бүх суманд нэвтрүүлж нэгдсэн сүлжээг бүрдүүлэх	-	бүх сумыг холбоно	Ч.Улаан Н.Энхболд
11	Санхүүгийн зах зээлийн байдалд чухал үүрэгтэй үл хөдлөх хөрөнгийн үнийн индексийг тооцох судлах хүрээнд орон сууцны үнийн индексийг тооцож эхлэх	-	2008 оны I улирлаас орон сууцны үнийн индексийг мэдээлж эхэлнэ	Ц.Цолмон П.Бямбацэрэн
11.1	"Орон сууцны барилгын үнийн индекс тодорхойлох аргачлал"-ыг гаргаж, орон сууцны үнийн индексийг тооцож эхлэх	-	-	П.Бямбацэрэн Ц.Цолмон
11.2	Баялгийн хуваарилалтыг айл өрх бүрт хүртээх ажлыг улс даяар явуулах хөрөнгийн бүртгэлтэй хослуулах	-	2007.12-2008.07	Ч.Улаан
11.2.1	Олон улсын стандартад эдийн засгийн бүх салбарын нягтлан бодох бүртгэлийг бүрэн шилжүүлэх ажлыг эрчимжүүлж жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд зориулсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх	-	2007.12-2008.07	Ч.Улаан
11.2.2	Хөрөнгийн үнэлгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах	-	2007.12-2008.07	Ч.Улаан
11.2.3	Өмч хувьчлалыг олон нийтэд ил тод байлгах, хүнд суртлыг арилгах зорилгод нийцүүлэн одоогийн мөрдөгдөж байгаа өмч хувьчлалын журмуудыг өөрчлөн мөрдүүлэх	-	2007.12-2008.07	Ч.Улаан Н.Энхболд

12	Санхүүгийн зуучлалын ертгийг хямдруулах үүднээс гадаадын урт хугацаатай хямд эх үүсвэртэй санхүүжилтийн төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	-	-	Ч.Улаан Д.Баярсайхан
13	Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд санхүүгийн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах	-	-	Ч.Улаан Ц.Мөнх-Оргил А.Батсүх Д.Баярсайхан
13.1	Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд Хадгаламжийн даатгалын тухай Хадгаламж зээлийн хоршооны тухай Хөгжлийн банкны тухай хуулиудыг тус тус батлуулах	-	-	Ч.Улаан Ц.Мөнх-Оргил Д.Баярсайхан
13.2	Валютын зохицуулалтын тухай хуулийн төслийг боловсруулах	-	-	Ч.Улаан Ц.Мөнх-Оргил Д.Баярсайхан
14	Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгон хөрөнгийн зах зээлийн арилжаа төлбөр тооцоог мэдээллийн технологийн шинэ системээр тоноглох	-	-	Д.Баярсайхан Ч.Улаан Ц.Мөнх-Оргил
14.1	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаагаар баталгаажсан ерийн бичгийн тухай Үнэт цаасжуулах болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төслүүдийг боловсруулж Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчныг сайжруулах	-	-	Д.Баярсайхан Ч.Улаан Ц.Мөнх-Оргил
15	Хөрөнгийн биржийн өмчийн харилцааг боловсронгуй болгож өөрчлөх	-	-	Д.Сугар Д.Баярсайхан
<i>Хоёр. Бодит салбарын бодлого</i>				
<i>Зорилт 3. Хувийн хэвшлийн хөгжлийг эдийн засгийн бүхий л хөшүүргээр дэмжих шинжлэх ухаан техникийн дэвшлийг үйлдвэрт нэвтрүүлэх замаар шинэ технологид суурилсан үйлдвэрлэл бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ</i>				
16	Хувийн хэвшил төрийн хамтын ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх, үндэсний үйлдвэрийг хамгаалан хөгжүүлэх төрийн бодлогыг тодорхой болгох	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Наранхүү Ч.Улаан Ц.Мөнх-Оргил
16.1	Төр нь иргэд бизнес эрхлэгчдэд үйлчлэх, дэмжиж туслах хэлбэрээр зохицуулалтаа хэрэгжүүлдэг байх хэм хэмжээг хэвшүүлэх	-	2007.12- 2008.07	Х.Наранхүү Н.Энхболд Д.Дэмбэрэл Засгийн газрын гишүүд

16.1.1	Төрөөс зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг үзүүлэх үйлчилгээний хүрээг хамгийн хялбар цэгцтэй байх хязгаарын хэмжээнд тодорхойлж бизнес эрхлэгчдэд таатай нөхцөл бүрдүүлэх шударга өрсөлдөөний орчныг бий болгох	-	2007.12- 2008.07	Х.Наранхүү Н.Энхболд Д.Дэмбэрэл Засгийн газрын гишүүд
16.1.2	Төрийн үйлчилгээний албанд хамаарах албан хаагчдын хүрээг багасгаж улмаар төрийн байгууллагын эрхэлж байгаа зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллага аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх явдлыг ажил хэрэг болгох	-	2007.12- 2008.07	Ч.Улаан Н.Энхболд Д.Дэмбэрэл Засгийн газрын гишүүд
16.1.2.1	Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх ерөнхий журам баталсан Засгийн газрын 1995 оны 111 дүгээр тогтоолыг шинэчлэх	-	2007.12- 2008.07	Ч.Улаан Н.Энхболд Ц.Мөнх-Оргил
16.1.2.2	Статистикийн үндэсний мэдээллийн сан болон сар, улирал, жил тутам гаргадаг статистикийн бюллетень танилцуулга, статистикийн эмхтгэлийг цахим хэлбэрээр гадаад, дотоодын хэрэглэгчдэд интернэтээр хүргэх үйлчилгээг нэвтрүүлэх	-	2007.12- 2008.07	П.Бямбацэрэн
16.1.2.3	Иргэд, төрийн бус байгууллагаас хүүхэд, насанд хүрэгчдэд бичиг үсэг сургах боловсрол нөхөн олгох үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлэхийг дэмжих	-	2007.12- 2008.07	Н.Болормаа Аймаг нийслэлийн Засаг дарга
16.1.2.4	Ерөнхий боловсролын сургуульд гадаадын болон хувийн хөрөнгө оруулалт хийх санаачилгыг дэмжих	-	2007.12- 2008.07	Н.Болормаа Ч.Улаан Аймаг нийслэлийн Засаг дарга
16.1.2.5	Хүн амд эрүүл мэндийн боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	-	2007.12- 2008.07	Б.Батсэрээдэнэ Н.Болормаа Аймаг нийслэлийн Засаг дарга
16.1.2.6	Иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, төрийн бус болон эрдэм шинжилгээний байгууллагуудаар байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх судалгаа шинжилгээ хийх, сургалт сурталчилгаа явуулах ажлуудыг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажлыг өргөжүүлэх	-	2007.12 - 2008.07	Г.Шийлэгдамба

16.2	Лиценз зөвшөөрлийн системийг зохистой хэмжээнд хүртэл цэгцлэн хувийн хэвшлийнхэн иргэдийн аж ахуй эрхлэх чөлөөт хөгжлөө хангах нөхцөл бололцоог төгөлдөрсүүлэх	-	2008.01- 2008.07	М.Энхболд Н.Энхболд Засгийн газрын гишүүд
16.3	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль бусад хууль тогтоомжоор зохицуулсан тусгай зөвшөөрлийн хэрэгжилтийн байдалд улсын үзлэг явуулж түүний мөрөөр лиценз болон тусгай зөвшөөрлийн нэр төрөл, хүрээг хязгаарлах чиглэлээр санал боловсруулах ажлыг зохион байгуулж ажиллах	-	2008.01- 2008.07	М.Энхболд Н.Энхболд Засгийн газрын гишүүд
16.4	Иргэний нийгэмтэй оновчтой түншилж ажиллан төрийн ачааллыг багасгаж итгэлцлийг бэхжүүлэх	-	2007.12- 2008.07	М.Энхболд Н.Энхболд
16.4.1	Хуулиар зөвшөөрөгдсөн аливаа мэдээллийг иргэдэд нээлттэй байлгах хяналт шалгалтын ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх	-	2007.12- 2008.07	М.Энхболд Н.Энхболд
17	Сумдад ажлын байр нэмэгдүүлэх жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх өрсөлдөх чадвартай үйлдвэрлэлийг дэмжих, тэргүүний техник, технологийг нэвтрүүлэх, уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлэх, бүсийн төв хотуудад үйлдвэрлэл технологийн парк байгуулах зорилгоор олон улсын санхүүгийн зах зээлд 1.2 тэрбум ам.доллар хүртэл хэмжээтэй Засгийн газрын бондыг борлуулан санхүүгийн бусад эх үүсвэрийг дайчлан 300.0 сая хүртэл ам.долларыг зарцуулах	парк байгуулах хот аймгийн тоо	3	Х.Наранхүү Ч.Улаан
		бондын арилжаа /тэрбум ам.доллар/	1.2	
		жижиг дунд үйлдвэр эрхлэх төвийн тоо	21	
		боловсруулах салбарын бүтээгдэхүүний ДНБ-д эзлэх хувь	5.5	
17.1	Олон улсын санхүүгийн зах зээлд Засгийн газрын бондыг борлуулах бэлтгэл ажлыг хангаж арилжаалах	-	-	Ч.Улаан
18	Эрдэнэтийн зэсийн баяжмалыг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх эхлэлийг тавих	-	-	Х.Наранхүү
19	Таван толгойн нүүрсийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх	-	-	Х.Наранхүү

19.1	Тавантолгойн орд газарт байгаа нүүрсний нөөцийг дэлхийн жишигт нийцэх аргаар зах зээлд гаргах	-	2007.12- 2008.07	Х.Наранхүү С.Оюун
19.1.1	Таван толгойн орд газрын тусгай зөвшөөрлийг төрийн мэдэлд шилжүүлж ордыг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх	-	-	Х.Наранхүү
19.1.1.1	Тавантолгойн орд газрыг төр давамгайлан эзэмших, ашиглах талаар гэрээ хэлэлцээр байгуулах ерөнхий нөхцөл журмыг гаргах	-	2007.12- 2008.07	Х.Наранхүү
19.1.1.2.	Тавантолгойн орд газрын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшиж байгаа компаниудтай хэлэлцэн зөвшилцөж тохиролцсоноор төрийн мэдэлд ордыг эзэмших тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авах	-	2008.05	Х.Наранхүү С.Оюун Засгийн газрын гишүүд
19.1.1.3	Төр тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авсны дараа гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нартай гэрээ хэлэлцээр хийх замаар Тавантолгойн орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах тодорхой алхмуудыг хийх	-	2008.05	Х.Наранхүү С.Оюун Засгийн газрын гишүүд
19.1.2	Тавантолгойн бүлэг орд газрыг төр дангаараа эзэмшиж хөрөнгө оруулагч компанийг төр сонгон төрийн нэрийн өмнөөс хэлэлцээ хийх	-	2007.12- 2008.07	Х.Наранхүү С.Оюун Засгийн газрын гишүүд
19.1.2.1	Тавантолгойн орд газрыг хамтран эзэмших, ашиглах стратегийн хөрөнгө оруулагчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгож улмаар стратегийн хөрөнгө оруулагчийг сонгох олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг олон улсын санхүүгийн байгууллагуудын туслалцаатайгаар зохион байгуулах чиглэлээр ажиллах	-	2007.12- 2008.07	Х.Наранхүү С.Оюун Засгийн газрын гишүүд
19.1.2.2	Тавантолгойн ордод Монгол Улсын төрийн баримтлах бодлого төсөл хэрэгжүүлэхэд оролцох хөрөнгө оруулагчдад тавих нөхцөл төр эзэмших хувь хэмжээ дэд бүтэц нийгмийн асуудлуудаар Монголын талын байр суурийг нарийвчлан тогтоож хөрөнгө оруулалтын гэрээг боловсруулахад бусад улс орны туршлага олон улсын байгууллагуудын зөвлөмж саналыг судалсны үндсэн дээр сонгон шалгаруулалт хийх	-	2008.05	Х.Наранхүү С.Оюун Засгийн газрын гишүүд
19.1.3	Тавантолгойн орд газрын ашиглалтын лицензийг эзэмшиж байгаа компаниудтай талуудыг хохироохгүйгээр тохиролцоонд хүрэх зорилгоор яриа хэлэлцээрийг эхлүүлэх хэлэлцэн зөвшилцөх	-	2007.12- 2008.07	Х.Наранхүү С.Оюун Засгийн газрын гишүүд

19.1.3.1	“Тавантолгой” ордын тусгай зөвшөөрлийг төрд шилжүүлэн авах асуудлыг судлан үзэж тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцээ явуулах ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулан ажиллуулах	-	2007.12- 2008.07	Х.Наранхүү С.Оюун Засгийн газрын гишүүд
20	Оюутолгойн зэс, алтны ордыг ашиглаж уул уурхай-металлургийн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах. Уг цогцолборыг ашиглахад шаардагдах эрчим хүчний эх үүсвэр цахилгаан дамжуулах шугам, зам тээврийн сүлжээ, усан хангамжийн барилга байгууламжийг барьж байгуулах түүнчлэн Дархан-Сэлэнгийн бүс нутаг дахь Төмөртэй, Баянгол, Төмөртолгойн төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн төмрийн хүдэр олборлох, баяжуулах, боловсруулах үйлдвэр байгуулж хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр засгийн зүгээс дэмжлэг үзүүлэх	-	-	Х.Наранхүү Ч.Хүрэлбаатар Р.Раш
20.1	Оюутолгойн гэрээг Монгол Улсад илүү ашигтай байдлаар олон улсын нэр хүнд бүхий хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар дэлхийн дэвшилт жишиг стандартад нийцүүлэн хийх	-	2007.12- 2008.06	Х.Наранхүү
20.1.1	Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс Оюутолгойн ордын хэлэлцээг олон улсын нэр хүндтэй байгууллагаар зуучлуулан явуулах санхүүгийн байгууллагыг тодорхой шалгуур үзүүлэлтээр сонгох, олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах хугацаа, нөхцөл, төлбөр төлөх эсэх асуудлаар санал боловсруулж Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон УИХ-д танилцуулан тодорхой зөвлөмж чиглэл авах замаар ажиллах	-	2007.12- 2008.06	Х.Наранхүү
20.1.2	Оюутолгойн ордод Монгол Улсын төрөөс баримтлах бодлого, төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчдад тавих нөхцөл төр эзэмших хувь хэмжээ дэд бүтэц нийгмийн асуудлаархи Монголын талын байр суурийг нарийвчлан тогтоож хөрөнгө оруулалтын гэрээний төслийг шинэчлэн боловсруулахад бусад улс орны туршлагыг судлан олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагыг сонгон Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс гэрээ хэлцэл хийх нөхцөлийг бүрдүүлэх	-	2007.12- 2008.06	Х.Наранхүү
20.1.3	Оюутолгойн ордын талаар Засгийн газраас өөрийн хүсэж буй нөхцөл шаардлага тавих	-	2007.12- 2008.06	Х.Наранхүү

20.1.3.1	Засгийн газраас Оюутолгойн ордыг Монгол Улсад үр ашигтайгаар ашиглах бүхий л боломжийг судлан үзэж олон улсын санхүүгийн байгууллагад тавих нөхцөл шаардлагыг нарийвчлан тодорхойлж улмаар төслийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Улсын Их Хуралд танилцуулж тодорхой зөвлөмж чиглэлийн дагуу ажиллах	-	2007.12- 2008.06	Х.Наранхүү
20.1.3.2	Оюутолгойн ордын талаар Монгол Улсын төрөөс баримтлах бодлого төсөл хэрэгжүүлэхэд оролцох хөрөнгө оруулагчдад тавих нөхцөл, төр эзэмших хувь хэмжээ, дэд бүтэц болон нийгмийн асуудлуудаар Засгийн газраас тавих шаардлагыг Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд тусгах	-	2007.12- 2008.06	Х.Наранхүү
21	Ураны орд газрыг ашиглах эрх зүйн таатай орчныг эн тэргүүнд бүрдүүлэхийн дээр энэ асуудлыг эрхлэн хариуцдаг бие даасан нэгж байгуулж түүний ажиллах чиг үүргийг тодорхойлох	-	-	Х.Наранхүү
22	Төмөртэйн хүдрийн бүсэд нүүрс, шохойн чулуу, доломит зэрэг металлургийн үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эдийн нэмэлт судалгаа хийх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Наранхүү
23	"Стратегийн ач холбогдол бүхий орд газар"-ын бүртгэл жагсаалтыг батлах	-	-	Х.Наранхүү
24	Асгатын мөнгөний орд газрыг ашиглах бэлтгэлийг хангах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Наранхүү
25	Газрын тосны хайгуул олборлолтыг нэмэгдүүлж газрын тос боловсруулах үндэсний үйлдвэр байгуулахыг төрөөс дэмжиж нүүрснээс нефть бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Наранхүү
26	Стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох буудай, нефть бүтээгдэхүүний улсын нөөцийг нэмэгдүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөг/	100-аас доошгүй	Ч.Улаан Ц.Ганхуяг
27	Эрдэс, түүхий эдийн нөөцийг өсгөх, геологийн хайгуул судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх хувийн хөрөнгөөр геологийн хайгуулын ажил хийгдэж буй зарим ордод хээрийн судалгаа болон суурин ажлын явцад хяналт тавих	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Наранхүү
27.1	Уул уурхайн нөхөн сэргээлтийн бодлого эрх зүйн орчныг боловсронгуй болгох	-	2007.12- 2008.06	Г.Шийлэгдамба Х.Наранхүү

27.1.1	Ашигт малтмалыг олборлох, баяжуулахад байгаль орчинд учруулах хохирлын экологи, эдийн засгийн үнэлгээ, төлбөр тооцох аргачлалыг боловсруулж мөрдүүлэх	-	2007.12- 2008.06	Г.Шийлэгдамба Х.Наранхүү
27.1.2	Нөхөн сэргээлтийн зардал тооцдог норм үнэлгээг шинэчлэн батлах	-	2007.12- 2008.07	Г.Шийлэгдамба
27.1.3	Уул уурхайн нөхөн сэргээлтийн стандартыг шинэчлэн баталж мөрдүүлэх	-	2007.12- 2008.07	М.Энхболд Г.Шийлэгдамба
28	Хөрш орнуудын болон олон улсын зах зээлийн боломжийг илүү ашиглах өндөр хөгжилтэй орнуудын зах зээлд бараа бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх боломжийг эрэлхийлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Наранхүү Ч.Улаан
29	Эдийн засаг, худалдааны чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж бүсүүдийн дэд бүтцийг бүрдүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	М.Энхболд Х.Наранхүү
29.1	Эдийн засаг, худалдааны чөлөөт бүс байгуулах бодлогыг үргэлжлүүлж хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдэд үйлчлэх мэдээллийн бааз сүлжээ байгуулах	-	2007.12- 2008.07	Х.Наранхүү
30	Бөөний худалдааг Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн хүрээнд зохион байгуулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Наранхүү
31	Жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр ажиллаж байгаа хэлтэс, алба, сан, төслүүдийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын агентлагийн бүтцэд шилжүүлэн Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд сум дүүрэг бүрт 30-аас доошгүй сая төгрөгөөр Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөрөнгийг нэмэгдүүлж ажлын байр бий болгох. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд өгөх зээлийн хүүгийн тодорхой хэсгийг төрөөс хариуцах зээлийн баталгааг гаргах механизмыг бүрдүүлж шалгарсан төслийг арилжааны банкаар дамжуулан санхүүжүүлэх, уг зээлийн хүүг жилийн 10 хувиас хэтрүүлэхгүй байх	-	-	Х.Наранхүү Ч.Улаан
Зорилт 4. Түлш, эрчим хүчний салбарт шинэчлэл хийж найдвартай ажиллагааг хангана				
32	Түлш, эрчим хүчний салбарт шинэчлэл хийж зах зээлийн зарчмаар ажиллах орчныг үе шаттайгаар хэрэгжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ч.Хүрэлбаатар

33	Чаргайт Эгийн голын усан цахилгаан станцыг барих ажлыг эхлүүлэх	хүчин чадал	228 мВт	Ч.Хүрэлбаатар
34	Улаанбаатар-Мандалговь-Тавантолгой-Оюутолгойн 220 кВт цахилгаан дамжуулах шугам дэд өртөөг барьж эхлэх	урт км	400.0	Ч.Хүрэлбаатар
35	Эрдэнэт-Эгийн голын усан цахилгаан станц Багануур-Чойбалсангийн 220 кВт цахилгаан дамжуулах шугамын зураг төслийг боловсруулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ч.Хүрэлбаатар
36	Тэлмэн-Могойн гол-Мөрөнгийн чиглэлд 110 кВт цахилгаан дамжуулах шугамыг барьж ашиглалтад оруулах	урт км	320	Ч.Хүрэлбаатар
37	Улаанбаатар хотод дулааны цахилгаан станцын 5 дахь эх үүсвэрийг барих ажлыг зохион байгуулах	хүчин чадал	400 мВт	Ч.Хүрэлбаатар
38	Шивээ-Овоо, Тавантолгой болон бусад нүүрсний ордод түшиглэсэн орчин үеийн өндөр үр ашигтай том хүчин чадлын дулааны цахилгаан станц байгуулах ажлыг эхлүүлэх	хүчин чадал	10000 мВт	Ч.Хүрэлбаатар
39	Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд технологийн шинэчлэл хийх	-	-	Ч.Хүрэлбаатар
40	Экологийн цэвэр түлшний үйлдвэрийг Улаанбаатар хотын 2 дугаар цахилгаан станцыг түшиглэн барьж ашиглалтад оруулах	үйлдвэрлэх түлшний хэмжээ /мян.тн/	150.0	Ч.Хүрэлбаатар Г.Шийлэгдамба
		цэвэр түлшээр хангагдах өрхийн тоо /мянгаар/	70.0	
41	Хийн түлшний салбарыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, төв суурин газарт хийн түлш ашиглах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зарим аймгийн төвд шингэрүүлсэн шатдаг хийг цэнэглэх цэг барих	хамрагдах аймгийн төв	8	Ч.Хүрэлбаатар Х.Наранхүү
Зорилт 5. Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлж аюулгүй байдлыг хангана				
42	Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл боловсруулалтын зохистой тогтолцоог бүрдүүлэх	-	-	Ц.Ганхуяг Х.Наранхүү

43	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэдээллийн улсын хэмжээний нэгдсэн сүлжээг бий болгох	-	-	Ц.Ганхуяг Н.Энхболд
44	Хүнсний баталгаат байдлын тогтолцоог олон улсын жишгийн дагуу шинэчлэх	-	-	Ц.Ганхуяг Н.Энхболд
45	Хүн амын хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулж лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлж нэгдсэн сүлжээг бий болгох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа нийтийн хоолны чанар, эрүүл ахуйд тавих шаардлагыг өндөржүүлэх	-	-	Ц.Ганхуяг Х.Наранхүү Ц.Шийрэвдамба
45.1	Хүнсний аюулгүй байдал хоол тэжээлийн чиглэлээр олон нийтэд зориулсан хэвлэл мэдээллийн сурталчилгааг өргөжүүлэх вэб хуудастай болох ажлыг зохион байгуулах	-	2007.12- 2008.07	Б.Батсэрээдэнэ Ц.Ганхуяг
46	Мах, махан бүтээгдэхүүний хангамж эрүүл ахуй чанарын шаардлагыг дээшлүүлэх зорилгоор Говь-Алтай, Завхан, Хөвсгөл, Өвөрхангай, Дундговь, Ховд, Баян-Өлгий, Сүхбаатар, Булган аймгуудад хөргөлттэй агуулах бүхий мал нядалгааны газрыг шинээр байгуулахад дэмжлэг үзүүлэх	үйлдвэрийн аргаар боловсруулагдсан махны хэмжээ /мян.тн/	19 -өөс доошгүй	Ц.Ганхуяг Ц.Цолмон
47	Төв, суурин газрын хүн амын мах, сүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилгоор арвин ашиг шимт мах, сүүний үүлдрийн үхрийг импортолж мах сүүний болон усалгаатай газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг загвар аж ахуйнуудыг бүсчлэн байгуулах хөтөлбөр төслүүдийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх	үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ /сая литр/	25.9	Ц.Ганхуяг
48	Төв, суурин газар болон хөдөөгийн иргэдийг дотоодын үйлдвэрлэлийн төмсөөр хангах түүний хадгалалтыг сайжруулах зорилгоор аймаг сумдын төвд хүнсний ногооны агуулах байгуулах гахай шувууны махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх "Гахай" "Дэгдээхэй" төслийг боловсруулж хэрэгжүүлэх	дотоодын хүнсний ногооны хангалтын хувь	55.0-аас доошгүй	Ц.Ганхуяг
		дотоодын тариалсан төмсний хангалтын хувь	95 -аас доошгүй	

49	2008 оныг "Хүнсний хангамж-аюулгүй байдлын жил" болгон зарлаж уг бодлогын хүрээнд мах гурилын үнийн өсөлтийг хязгаарлаж хангамж нийлүүлэлтийг тогтвортой байлгах зорилгоор махны нөөц бэлтгэх гурилын хэрэгцээг ойрын 3 жилд дотоодоосоо хангах зорилт дэвшүүлэн улаан буудайг "Буудайн сан"-гаар дамжуулан худалдан авч 1 тн тутамд 80.000 төгрөгийн урамшуулал олгох газар тариалангийн техник хэрэгслийг лизингээр ашиглуулах лизингийн төвүүдийг байгуулах	дотоодын үйлдвэрлэлээр хангах гурилын хангалтын хувь	43.0	Ц.Ганхуяг
		буудайн хэмжээ /мян.тн/	130.0	
49.1	"Хүнсний аюулгүй байдлын жил"-ийн нээлтийн ажиллагааг зохион байгуулах	-	2007.12-2008.07	Ц.Ганхуяг
49.2	"Хүнсний аюулгүй байдлын жил"-ийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн явцыг иргэдэд мэдээлэх олон түмний санал бодлыг салбарын бодлого шийдвэрт тусгах "Иргэдийн санал хүсэлтийг хүлээж авах байр"-ыг нээж ажиллуулах	-	2007.12-2008.07	Ц.Ганхуяг
Зорилт 6. Мал аж ахуйн салбарын байгалийн эрсдэл даах чадавхийг бэхжүүлж бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хөдөөгийн хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлнэ				
50	Бүс нутгийн онцлогийг харгалзан хот айл малчдын бүлэг эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд бэлчээрийг гэрээгээр эзэмшүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж бэлчээр усны нөөцийг зохистой ашиглах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ц.Ганхуяг
51	Аймаг дундын отрын бүс нутгуудыг хамгаалалтад авч усжуулах материаллаг баазыг нэмэгдүүлэх түүнийг хариуцсан нэгжийг ажиллуулж үйл ажиллагааг нь жигдрүүлэх	отрын бүс нутгийн тоо	3	Ц.Ганхуяг
52	Эрчимжсэн аргаар үхэр хонь үржүүлэхийн зэрэгцээ нутгийн шилмэл үүлдэр омгийн малыг сонгон үржүүлэх цөм сүргийн үржлийн төвийн үйл ажиллагааг жигдрүүлэх	цөм сүргийн тоо /мян.толгой/	1130.0	Ц.Ганхуяг
53	Бэлчээр дэх эвдэрсэн худагт засвар шинэчлэлт хийх, шинээр худаг гаргах, иргэдийн оролцоотойгоор гар худаг гаргах үйл ажиллагааг дэмжих	шинээр гаргах инженерийн хийцтэй худгийн нийт тоо	1700-аас доошгүй	Ц.Ганхуяг
		засварлах худгийн тоо	375	

54	Бэлчээр тариалангийн талбайн хортон мэрэгч шавжтай тэмцэх ажлыг хүрээлэн буй орчинд халгүй үр нөлөөтэй дэвшилтэт технологи, арга хэлбэрээр зохион байгуулах	энгийн болон биологи химийн аргаар тэмцэх талбай /мян.га-гаар/	680.0	Ц.Ганхуяг Г.Шийлэгдамба
55	Тариалан тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх малын тэжээлийн үйлдвэрийг сэргээх арга хэмжээ авах	хураан авах ургац /мян.тн/	12.0	Ц.Ганхуяг
56	Мал, амьтны гоц халдварт болон халдварт, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоог нэмэгдүүлэх, үхрийн доголох өвчин болон түгээмэл тархалттай байгаа эрдсийн дутагдлаас үүсэх өвчнөөс урьдчилан сэргийлэх халдварт өвчний тархалт гаралтыг бууруулах	хамрагдах малын тоог нэмэгдүүлэх хэмжээ	2.3 дахин	Ц.Ганхуяг
57	Монгол Улсыг үхрийн цээж өвчнөөр тайван орны жагсаалтад оруулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	жагсаалтад орсон байх	Ц.Ганхуяг
58	Цаатан иргэд, тэмээчдийн амьжиргааг дээшлүүлэх цаа буга, тэмээн сүргийг тогтвортой өсгөх эрх зүйн орчныг сайжруулж тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ц.Ганхуяг
Зорилт 7. Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах зорилгоор усалгаатай газар тариалангийн хэмжээг нэмэгдүүлнэ				
59	Услалтын системийн барилга байгууламжийг шинэчлэх, засварлах, шинээр барьж байгуулах газар тариаланд техникийн шинэчлэл хийх	усалгаатай нөхцөлд тариалах тариалангийн талбайн хэмжээ /мян.га-гаар/	35.0	Ц.Ганхуяг
59.1	"Атрын III аян"-ы хүрээнд газар тариалангийн салбарыг шинэ түвшинд тодорхойлон хөгжүүлэх	-	2007.12- 2008.07	Ц.Ганхуяг
60	Усалгаатай тариалан эрхлэх талбайн хайгуул хийх техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, бэлчээрийн усны хайгуул судалгааг эрчимжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ц.Ганхуяг
60.1	Улсын эрдэм шинжилгээний байгууллага аж ахуйн нэгж иргэдтэй гэрээ байгуулан цөм сүрэг таримал ургамлын сайн чанарын үр үйлдвэрлэх ажлыг зохион байгуулна	-	2007.12- 2008.07	Ц.Ганхуяг Аймаг нийслэлийн Засаг дарга

61	Мал аж ахуй, газар тариалан эрхэлж буй иргэн аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх бага оврын трактор цахилгаан үүсгүүр хадлангийн болон газар тариалангийн техник хэрэгслийн тоог нэмэгдүүлэх	бага оврын техник хадлангийн тоног хэрэгслээр хангагдах өрх, аж ахуйн нэгжийн тоо	4000	Ц.Ганхуяг
Зорилт 8. Барилга, хот байгуулалт газар зохион байгуулалтын төлөвлөлтийг сайжруулж иргэдийг орон сууцаар хангах инженерийн шугам сүлжээг өргөтгөх арга хэмжээ авна				
62	"40000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хот болон бүсийн тулгуур төв хотуудын гэр хорооллыг дахин төлөвлөлт хийх замаар орон сууцны хороолол болгох төвлөрсөн инженерийн хангамжид холбох	ашиглалтад орох орон сууцны тоо	10000 айл	Ц.Цолмон Ч.Хүрэлбаатар
62.1	"40000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд цахилгаан болон дулааны сүлжээг өргөтгөх зураг төслийг хийх ажлыг зохион байгуулах	-	-	Ч.Хүрэлбаатар Ц.Цолмон
62.2	"40000 орон сууц" хөтөлбөрийг эрчимжүүлэн 2713 айлын орон сууцыг шинээр барьж ашиглалтад оруулах	-	-	Ц.Цолмон
62.3	Орон сууцны ХИҮ, VII, Радио телевизийн Хэрэг эрхлэх газрын орчмын болон Гандан хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх	-	-	Ц.Цолмон Т.Билэгт
63	Хүн амыг орон сууцаар хангах зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ипотекийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлж "40000 орон сууц"-ны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	-	-	Ц.Цолмон Ч.Улаан
63.1	Үл хөдлөх эд хөрөнгөөр баталгаажсан өрийн бичгийн тухай Үнэт цаасжуулах болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай Хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулах	-	-	Ч.Улаан Д.Баярсайхан Ц.Цолмон
63.2	Засгийн газрын бондын хөрөнгөөр иргэдэд орон сууцны урт хугацаатай зээл олгох ажлыг эхлүүлэх	-	-	Ц.Цолмон Ч.Улаан
64	Автомашин зогсоол, унадаг дугуй, тахир дутуу иргэдийн дэд бүтцийн тусгай байгууламж тэдгээрт тавих шаардлагыг хот төлөвлөлтийн стандартад нийцүүлэх барилгын зураг төсөвт тусгаж хэвшүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ц.Цолмон
64.1	Авто зогсоолын стандартыг шинээр боловсруулж хэрэгжүүлэх	-	-	Ц.Цолмон

65	Замын-Үүд, Цагааннуурын чөлөөт бүс Хархорин Эрдэнэзуугийн аялал жуулчлалын төв Тавантолгой, Оюутолгой, Цагаан суваргын уул уурхайн цогцолборыг түшиглэсэн бүс нутгийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах	ерөнхий төлөвлөгөө хийх тоо	4	Ц.Цолмон
65.1	"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ инженер геологийн судалгаа инженерийн хангамж эх үүсвэрийн хэрэглээг тооцох арга хэмжээ авах	-	-	Ц.Цолмон
65.2	"Цагааннуур" худалдааны чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах	-	-	Ц.Цолмон Р.Раш
65.3	Хархорин, Эрдэнэзуу орчмыг аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах	-	-	Ц.Цолмон Р.Раш
65.4	Говийн бүсийн Тавантолгой, Оюутолгой, Цагаан суваргын уул уурхайн орд газрыг түшиглэсэн бүс нутгийн хөгжлийн стратеги хот байгуулалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	-	-	М.Энхболд Ц.Цолмон
65.4.1	"Галбын говь"-ийн эрчимтэй хөгжлийн дэд бүс байгуулах нөхцөл эрх зүйн орчныг бүрдүүлэх	-	2007.12- 2008.07	М.Энхболд Ц.Цолмон
66	Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх	ашиглалтад орох барилгын материалын үйлдвэрийн тоо	10	Ц.Цолмон
		цемент үйлдвэрлэл /мян.тн/	300.0	
66.1	Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	-	Ц.Цолмон
66.2	Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын харилцаа хөрөнгийн үнэлгээний ажил үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог боловсронгуй болгож ажил үүргийн давхардлыг арилгах замаар шат дамжлагыг эрс цөөлөх арга хэмжээг хэрэгжүүлэх	-	2007.12- 2008.07	Ц.Цолмон

67	<i>Хот, суурин газрын инженерийн шугам сүлжээг сайжруулах гэр хорооллыг цэвэр, бохир усны нэгдсэн сүлжээнд холбох ажлыг эрчимжүүлэх</i>	<i>шинэчлэх болон шинээр барих инженерийн шугам сүлжээний урт /км-ээр/</i>	<i>цэвэр усны шугам 255</i>	Ц.Цолмон
			<i>бохир усны шугам 108.4</i>	
			<i>дулааны шугам 42.6</i>	
		<i>цэвэр бохир усны нэгдсэн сүлжээнд холбогдох өрх гэрийн тоо</i>	<i>3990</i>	
67.1	<i>"Сум, суурин газрын дулаан хангамжийн шинэчилсэн хөтөлбөр"-ийг боловсруулж хэрэгжүүлэх</i>	-	-	Ц.Цолмон
67.2	<i>Аймгийн төвүүдийн дулаан хангамжийн судалгаа хийх техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах</i>	-	-	Ц.Цолмон
67.3	<i>Улаанбаатар хотын 5 дахь эх үүсвэрийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах</i>	-	-	Ц.Цолмон
67.4	<i>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цэвэр усны 150 км, бохир усны 34 км шугам, гадаадын зээл, тусламжийн хүрээнд цэвэр усны 100 км, бохир усны 60 км шугам сүлжээг засварлах</i>	-	-	Ц.Цолмон
67.5	<i>Баянголын амнаас Найрамдал зуслан хүртэлх цэвэр, бохир ус, дулааны шугам барьж ашиглалтад оруулах</i>	-	-	Ц.Цолмон
67.6	<i>14-р хорооллын дулааны 16 магистрал ил шугам Буянт-Ухаагийн дулааны 13-р магистрал ил шугамуудыг далд сувагт тавих, өргөтгөх, насосны станц барьж ашиглалтад оруулах</i>	-	-	Ц.Цолмон
67.7	<i>Бохир усны 25-р коллекторын 2-р ээлжийн шугам барих</i>	-	-	Ц.Цолмон

67.8	7-р хорооллын болон Радио телевизийн Хэрэг эрхлэх газрын орчны хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээг шинээр барих	-	-	Ц.Цолмон
68	Газрын мэдээллийн үндэсний системийг байгуулах ажлыг эхлүүлэх	мэдээллийн системийн бүрдүүлэлт /хувиар/	40.0	Ц.Цолмон
68.1	Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл зураглалын ажлыг орчин үеийн газар зүйн мэдээллийн системийн шаардлагад нийцүүлэн боловсруулах ажлыг зохион байгуулах	-	2007.12- 2008.07	Ц.Цолмон
68.2	Газрын нэгдмэл сангийн тооллого явуулж газрын тоо бүртгэлийг Үндэсний газрын мэдээллийн системийн шаардлагад нийцүүлэх	-	2008.07	Ц.Цолмон
68.3	"Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн бодлогын баримт бичиг"-ийг батлуулах	-	2008.07	Ц.Цолмон
68.4	Үндэсний газрын мэдээллийн систем /ҮГМС/-ийн техник, тоног төхөөрөмж суурилуулах, программ хангамжийг суулгаж тохируулах, холбох, зохион байгуулалтын арга хэмжээ авах	-	2008.07	М.Энхболд Ц.Цолмон Н.Энхболд
68.5	Газар болон газраас үүдэлтэй бусад байгалийн нөөцийн өгөгдлийн санг бүрдүүлэхэд шаардлагатай ISO19115 стандартыг холбогдох байгууллагуудад мөрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах	-	2008.07	Ц.Цолмон
68.6	Мэдээлэл холбооны сүлжээг ашиглан үндэсний газрын мэдээллийн санг бий болгож бүс нутгийн хөгжил, хот байгуулалт газар зохион байгуулалтын ажлын уялдааг хангаж мэдээллээр хөнгөн шуурхай үйлчлэх боломжийг бүрдүүлэх	-	2007.12- 2008.07	М.Энхболд Ц.Цолмон Н.Энхболд
68.7	Хөрөнгийн эрхийн бүртгэлийг байршлын кодоор зохицуулах тогтолцоо бий болгох	-	2007.12- 2008.07	Ц.Цолмон
68.7.1	Монгол Улсын гадаад дахь үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг нэгтгэн гаргах	-	2007.12- 2008.07	Ц.Цолмон С.Оюун
68.8	Автозам замын байгууламжийн паспортжуулалт хөрөнгийн бүртгэлийг шинэчлэн мэдээллийн санг бий болгож элэгдлийг тооцох даатгалын тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авах	-	2007.12- 2008.07	Р.Раш

68.9	Мянганы сорилтын сангийн төслийн хүрээнд хөрөнгийн эрхийн бүртгэлийг байршлын зурган мэдээлэлтэй холбон мэдээллийн цогц үйлчилгээг бий болгох бэлтгэл арга хэмжээг авч хэрэгжүүлнэ	-	2008.07	Ц.Цолмон
68.10	Германы "Хотын иж бүрэн хөгжил болон барилгын үйлдвэрлэлийг дэмжих" төслийн /GTZ/ хүрээнд барилгын мэдээллийн сан бүрдүүлэх	-	2008.07	Ц.Цолмон
69	Хот, суурин газрын кадастрын хүрээнд барилга байшинд чанар зориулалтын ангилал тогтоож регистрийн дугаар олгох	регистрийн дугаар олголт /хувиар/	30.0	Ц.Цолмон
69.1	Барилга байгууламжийн паспорт хувийн хэрэг хөтлөх регистрийн дугаар олгох, паспортжуулах үйл ажиллагааг журамлах	-	-	Ц.Цолмон
70	Ундны баталгаат цэвэр усны хангамжид хамрагдах төв, суурин газрын хүн амын тоог нэмэгдүүлэх	ундны баталгаат цэвэр усны хангамжид шинээр хамрагдах иргэдийн тоо /мян.хүн/	50.0-аас доошгүй	Ц.Цолмон Г.Шийлэгдамба
70.1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сум, суурин газрын 20 орчим худагт ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулах	-	-	Ц.Цолмон
70.2	Хот, суурин газрын цэвэр усны шугам сүлжээг шинэчлэх, шинээр барих ажлыг үргэлжлүүлэх	-	-	Ц.Цолмон
Зорилт 9. Эдийн засгийн бүсүүд болон олон улсын чанартай автозамын сүлжээг өргөтгөх ажлыг эрчимжүүлнэ				
71	Азийн автозамын сүлжээний АН-32 АН-4 АН-3 чиглэлийн болон Мянганы замын хэвтээ босоо тэнхлэгийн автозамыг үргэлжлүүлэн барих Үүнд: -Хануйн гүүр-Чулуутын гүүр, Хархорин-Цэцэрлэг, Улаанбаатар-Эрдэнэсант, Ховдын Булган-Үенч, Дашинчилэн-Орхоны гүүрийн чиглэлийн замыг барьж ашиглалтад оруулах -Чойр-Сайншанд-Замын-Үүд, Чулуутын гүүр-Тосонцэнгэл, Улаанбайшинт-Өлгий-Ховд-Ярант, Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн замыг үргэлжлүүлэн барих -Өлгий-Толбо-Ховдын чиглэлийн замыг тавьж эхлэх	баригдах автозамын урт /км-ээр/	500	Р.Раш
72	Авто замын хэвтээ, босоо тэнхлэгүүдийг байгуулж ойрын 5 жилд бүх аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох бодлого баримтлах	-	-	Р.Раш

73	Улаанбаатар-Мандалговь-Даланзадгадын чиглэлийн хатуу хучилттай автозамын ажлын зураг төслийг боловсруулах ажлыг дуусгаж зам барих ажлыг эхлүүлэх	эхний ээлжинд барих замын урт /км-ээр/	500	Р.Раш
74	Улаанбаатар хотын авто замын сүлжээний нэвтрүүлэх чадварыг сайжруулах, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, Монгол Улсын төмөр замын тээх, нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор зүтгүүр вагоны паркийг нэмэгдүүлэх	хөрөнгө оруулалтын хэмжээ /тэрбум төгрөг/	10.0-15.0	Р.Раш
75	Аялал жуулчлалын бүс нутгийн автозамыг сайжруулах хүрээнд Хатгал-Жанхай-Тойлогтын чиглэлийн хайрган зам Хархорин-Хужирт, Хөшөө цайдам-Өгий нуур чиглэлийн замыг засаж сайжруулан ашиглалтад оруулж Мөрөн-Хатгалын замыг эхлүүлэх	баригдах автозамын урт /км-ээр/	108	Р.Раш
76	Улсын чанартай автозамын засвар арчлалтыг өргөжүүлж замын хиймэл байгууламжийг сайжруулах тэмдэгжүүлэх замын дэржигнүүрийг арилгах шаардлагатай хэсэгт замын туузан хашлага тавих	-	улсын чанартай автозам бүрэн тэмдэгтэй болно	Р.Раш
Зорилт 10. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж бүх төрлийн тээврийн хөгжлийг эрчимжүүлнэ				
77	Дамжин өнгөрөх тээврийн тухай Монгол-Орос-Хятадын гурван талт хэлэлцээрийн явцыг эрчимжүүлж эцэслэн тохирох	-	гэрээ бэлэн болсон байна	Р.Раш
78	Говийн болон Зүүн бүсийн төмөр замын сүлжээ байгуулах, төмөр замыг цахилгаанжуулах авто хориглолоор тоноглох техник, эдийн засгийн үндэслэл, судалгаа, зураг төслийг боловсруулах	-	Техник, эдийн засгийн үндэслэлүүдийг боловсруулж дуусгана	Р.Раш
79	"Говийн бүсийн төмөр зам" төслийг хэрэгжүүлж эхлэх	-	-	Р.Раш
80	Замын-Үүдээр төмөр замаар болон авто замаар ачаа нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх	-	-	Р.Раш
81	Говь-Алтай, Увс, Завхан, Баян-Өлгий аймгийн нисэх буудалд хатуу хучилттай аэродром барих ажлыг эхлүүлж Говь-Алтайд зорчигч үйлчилгээний барилгыг ашиглалтад оруулах	хатуу хучилттай аэродром барих аймгийн тоо	4	Р.Раш

82	Нислэгийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулж Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрөх олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх	жилд дамжин өнгөрөх нислэгийн тоо	60000-аас доошгүй байх	Р.Раш
83	Улаанбаатарын ойролцоо Хөшигтийн хөндийд олон улсын шинэ нисэх буудал барих ажлыг эхлүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Р.Раш Ч.Улаан
83.1	Улаанбаатар хотын ойролцоо Хөшигтийн хөндийд Олон улсын нисэх буудлын хотхон байгуулах төслийг боловсруулах	-	-	Ц.Цолмон Р.Раш
84	Дотоодын агаарын тээврийн үйл ажиллагааг өргөжүүлж олон улсын нислэг, зорчигчдын тоог нэмэгдүүлэх	зорчигчдын тооны өсөлт /хувиар/	8.0-аас дээш	Р.Раш
85	Хөлөг онгоцны бүртгэлийн ажиллагааг нэмэгдүүлж далайн худалдааны тээвэрлэлтийн найдвартай үйлчилгээг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх	шинээр бүртгэх хөлөг онгоцны тоо	200	Р.Раш
86	Олон улсын жишигт хүрсэн аялал жуулчлалын томоохон цогцолбор зочид буудал барихыг дэмжих	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Р.Раш
Зорилт 11. Орчин үеийн мэдээлэл холбооны технологид тулгуурласан оюуны үйлдвэрлэлийн шинэ салбарыг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ				
87	Ази Европыг холбосон мэдээллийн өндөр хурдны холболт үүсгэх техникийн нөхцөлийг судалж шийдвэрлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Н.Энхболд
88	Орчин үеийн мэдээллийн технологийн олон улсын сүлжээг ашиглан оюуны хөдөлмөр эрхлэх нөхцөлийг сонирхогч улс орнуудтай хамтран бүрдүүлж хэрэгжүүлж эхлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Н.Энхболд Ч.Сайханбилэг
89	Мэдээллийн технологийн программ хангамжийн түвшинг сайжруулж "Цахим засаглал" хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын мэдээллийн төв байгуулах уг хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Н.Энхболд Ч.Сайханбилэг
89.1	Төрийн ой санамжийг сэргээх	-	2007.12- 2008.07	Н.Энхболд Засгийн газрын гишүүд
89.1.1	"Цахим засаглал" хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын бүртгэл лавламжийн сан бий болгож лавлагааны нэгжийг нэмэгдүүлэх	-	2007.12- 2008.07	Ц.Мөнх-Оргил

89.1.1.1	Хууль, хууль тогтоомжийн нэгдсэн сан бүрдүүлэх мэдээллээр үйлчлэх	-	2007.12- 2008.07	Ц.Мөнх-Оргил
89.1.1.2	Эрх зүйн мэдээллийн цахим санг хөтлөх, мэдээллийн бусад сан бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх	-	2007.12- 2008.07	Ц.Мөнх-Оргил
89.1.1.3	Нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт буюу Монгол Улсын сайд, аймаг нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн даргын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг бүртгэж лавлагаа өгөх	-	2007.12- 2008.07	Ц.Мөнх-Оргил
89.1.2	Салбарын статистик мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх, лавлагаа өгөх	-	2007.12- 2008.07	Н.Энхболд П.Бямбацэрэн Засгийн газрын гишүүд
89.1.2.1	"Газар зүйн мэдээллийн систем"-д суурилсан хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэдээллийн цогц бааз байгуулж вэб хуудсаар нэг цэгийн үйлчилгээг үзүүлж, мэдээллийг иргэдэд нээлттэй хүртээмжтэй үр нөлөөтэй болгох	-	2007.12- 2008.07	Ц.Ганхуяг
89.1.2.2	Иридиум сансрын хөдөлгөөнт холбооны гар утсыг үүрэн телефоны сүлжээгүй орон нутагт ашиглан мэдээллийг шуурхай дамжуулах боломж бүрдүүлэх, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах чадавхи бүрдүүлэх	-	2007.12- 2008.07	Ц.Ганхуяг
89.2	Шилэн кабельд холбогдсон аймгийн төв, сум суурин газрыг интернэтэд холбох ажлыг өргөжүүлж статистикийн мэдээллийг сүлжээгээр авах технологид шилжүүлэх	-	2007.12- 2008.07	Н.Энхболд П.Бямбацэрэн
89.3	"Цахим засаглал" дэд хөтөлбөрийн мастер /ерөнхий/ төлөвлөгөөг боловсруулж батлах	-	2007.12- 2008.07	Н.Энхболд Ч.Сайханбилэг
89.4	"Цахим Засгийн газрын нэгдсэн вэб сайт" төсөл хэрэгжүүлэх	-	2007.12- 2008.07	Н.Энхболд Ч.Сайханбилэг

89.5	Хуулийн этгээд байгууллагын домэйн хаяг цахим шуудангийн хаягтай болгох	-	2007.12- 2008.07	Н.Энхболд Засгийн газрын гишүүд
89.6	Интернэт худалдаа, үйлчилгээ, зайны сургалт, цахим нийтлэл, зайны оношилгоог эрчимтэй нэвтрүүлэх	-	2007.12- 2008.07	Н.Энхболд Засгийн газрын гишүүд
89.7	"Цахим Монгол" хөтөлбөртэй уялдуулан экспорт импорт худалдаа үйлчилгээтэй холбоотой лиценз зөвшөөрлийг сүлжээгээр дамжуулан олгох бэлтгэлийг хангах	-	2007.12- 2008.07	Х.Наранхүү
89.8	Шуудангийн зип кодыг улс орны хэмжээнд нэвтрүүлэх арга хэмжээ авах	-	2007.12- 2008.07	Р.Раш
90	Интернэтийн олон улсын гарцын хурдыг өндөр хурдны технологид шилжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Н.Энхболд Ч.Сайханбилэг
<i>Гурав. Бүс нутаг хөдөөгийн хөгжил байгаль орчны бодлого</i>				
<i>Зорилт 12. Бүсчилсэн хөгжлийн эрх зүйн орчныг сайжруулж бүс нутаг бүсийн тулгуур төвүүдийн хөгжлийг дэмжинэ</i>				
91	Төв, Хангайн бүсийн хойд хэсэгт "Хөвсгөл-Сэлэнгэ" говийн хэсэгт "Галбын говь"-ийн эрчимтэй хөгжлийн дэд бүс байгуулах нөхцөлийг бүрдүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	М.Энхболд Ц.Цолмон Х.Наранхүү Р.Раш
91.1	Төв, Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан "Хөвсгөл-Сэлэнгэ"-ийн эрчимтэй хөгжлийн дэд бүсийн онцлогт тохирсон хот байгуулалтын бодлого боловсруулах	-	-	М.Энхболд Ц.Цолмон Х.Наранхүү
91.2	Хөвсгөл Байгалийн ай сав нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх	-	2007.12- 2008.07	Р.Раш
91.3	Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан "Галбын говь"-ийн эрчимтэй хөгжлийн дэд бүсийн онцлогт тохирсон хот байгуулалтын бодлого боловсруулах	-	-	М.Энхболд Ц.Цолмон Х.Наранхүү
91.4	Өмнөд Говийн бүс нутгийн ашигт малтмалын ордуудад тулгуурлан уул уурхайн цогцолбор байгуулах хөтөлбөр боловсруулах	-		М.Энхболд Ц.Цолмон Х.Наранхүү

92	Бүсийн тулгуур төв хотуудыг түшиглэн түүхий эд бэлтгэх, шинэ тогтолцоог бий болгох	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	М.Энхболд Х.Наранхүү Ц.Ганхуяг
93	Алтанбулаг Цагааннуурын чөлөөт бүсэд дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж эхлэх	хөрөнгө оруулалтын хэмжээ /тэрбум төгрөг/	10.0-аас доошгүй	М.Энхболд Х.Наранхүү
94	Бүсийн захирагчдын албыг байгуулж тус албаны ажиллах эрх зүйн орчныг хуульчлах, бүсийн тулгуур төвүүдэд чиглэгдсэн хөрөнгө оруулалтыг дэмжих	-	-	М.Энхболд Ч.Улаан
95	Хөдөөгийн сум, суурин газрын эрчим хүчний хангамжийг шийдвэрлэх	эрчим хүчний төвлөрсөн эх үүсвэрт холбогдох сумын тоо	33	М.Энхболд Ч.Хүрэлбаатар
		сэргээгдэх эрчим хүчинд холбогдох сумын тоо	13	
96	Малчин өрхийг эрчим хүчний сэргээгдэх эх үүсвэрээр хангах	малчин өрхийн хамрагдалт /хувиар/	100.0	М.Энхболд Ч.Хүрэлбаатар Ч.Сайханбилэг
97	Хөдөөгийн бүх сумын төвийг гар утасны сүлжээтэй болгох техникийн асуудлыг шийдэж малчин өрхийг холбоожуулж эхлэх	үүрэн холбооны сүлжээнд холбох сумын тоо	200	М.Энхболд Н.Энхболд
Зорилт 13. Байгалийн нөөцийн менежментийн шинэ тогтолцоог нэвтрүүлж байгаль орчны бохирдлыг бууруулна				
98	Байгаль орчныг бохирдуулсны хариуцлага тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Г.Шийлэгдамба
99	Байгаль орчныг хамгаалах ажлыг нутгийн иргэдэд түшиглэн явуулах зорилгоор байгалийн нөөцийг иргэдийн нөхөрлөлд эзэмшүүлэх тогтолцоог нэвтрүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Г.Шийлэгдамба

100	Ойн бодлогын шинэчлэлийг хийж ойг нөхөн сэргээх, тарьж ургуулах, хортон шавжтай тэмцэх	ойжуулах талбай /га-гаар/	10000	Г.Шийлэгдамба
		ойн хортонтой тэмцэх талбай /га-гаар/	34000	
		ойн зохион байгуулалт хийх талбай /сая.га-гаар/	15	
		улсын ойн санд хүлээж авах таримал ой /га-гаар/	5000	
101	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах	түүхий нүүрсний хэрэглээг бууруулах хувь	30.0	Г.Шийлэгдамба Т.Билэгт
		агаарт ялгарах нүүрсхүчлийн хийг бууруулах	1 гкал дулаан үйлдвэрлэхэд ялгарах давхар ислийг багасгаж 0.53 болгоно	
102	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор ногоон байгууламжийг өргөжүүлж ботаникийн цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлэх	талбайн хэмжээ /га-аар/	100	Г.Шийлэгдамба Т.Билэгт
103	Улаанбаатар хотын утааг бууруулах чиглэлээр зуслангийн айлуудын цахилгаан хангамжийг бүрэн шийдвэрлэх	-	-	Ч.Хүрэлбаатар Т.Билэгт
104	Уул уурхайн олборлолтоор эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх	техникийн сэргээлт /хувиар/	60.0	Г.Шийлэгдамба Х.Наранхүү
		биологийн нөхөн сэргээлт /хувиар/	25.0	Г.Шийлэгдамба Х.Наранхүү
105	Томоохон хот суурин газрын хог хаягдлыг булаах, устгах ландфилийн аргыг нэвтрүүлж эхлэх	ландфилийн арга нэвтрүүлэх газрын тоо	2	Г.Шийлэгдамба

106	Химийн хорт бодисоор бохирдсон газар нутгийн хөрс усыг хоргүйжүүлэх арга хэмжээ авах иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх	-	-	Г.Шийлэгдамба
107	Ган цөлжилтөд нэрвэгдсэн говийн аймгуудын нутаг дэвсгэрийн цаг агаарт зориудаар нөлөөлөх замаар хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх	үүлэнд нөлөөлөх бүсийн төв байгуулах	5	Г.Шийлэгдамба
108	Улиастай, Өндөрхаан, Сүхбаатар, Эрдэнэт хотуудын усан хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааг хийн эрүүл ахуйн шаардлага хангасан ундны цэвэр усаар хүн амыг хангах	хайгуул хийх газрын тоо	4	Г.Шийлэгдамба Ц.Цолмон Ц.Ганхуяг
		ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх сумын тоо	30-аас доошгүй	Г.Шийлэгдамба Ц.Цолмон
108.1	Эрдэнэт хотын инженерийн шугам сүлжээг шинэчлэх төсөл хэрэгжүүлэх	-	-	Г.Шийлэгдамба Ц.Цолмон
108.2	Улиастай хотод цэвэр усны шугам усан сан барих	-	-	Г.Шийлэгдамба Ц.Цолмон
108.3	"Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх 2-р үе шатны төсөл"-ийн хүрээнд Өндөрхаан, Сүхбаатар хотуудын цэвэр бохир усны шугам сүлжээг шинэчлэх	-	-	Г.Шийлэгдамба Ц.Цолмон
109	Усны ундаргыг хамгаалах ширгэсэн гол горхийг сэргээх, хурын усаар шинэ усан сан, хөв байгуулах, усыг ашиглах, дахин ашиглах, цэвэршүүлэх орчин үеийн технологийг холбогдох бүх салбарт нэвтрүүлэх	булаг, гол горхины эхийг хаших /тоогоор/	200-аас доошгүй	Г.Шийлэгдамба Ц.Цолмон
		усан сан, хөв байгуулах /тоогоор/	аймаг бүрт 3-аас доошгүй	
